



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ
БАЙГУУЛЛАГУУДАД

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
АЛБА**

Баянголын 1 дүгээр гудамж, 27 дугаар хороо,
Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот, 18082
Утас: (976) 7000 0717
Цахим шуудан: haaashd24@gmail.com

2024.03.14 № 189
танай _____-ны № _____-г

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

СХД-ийн Худалдан авах ажиллагааны албанаас зарлагдсан “Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 34 дүгээр хороо)” НХААГ/20240101026 дугаартай ажилд оролцохоор байгууллага тодруулга хүссэн байна. Хүсэлтийн дагуу үнэлгээний хороо 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр хуралдаж тодруулгын хариуг хүргүүлж байна. Үүнд:

Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.3-д заасан тусгай зөвшөөрөлд шаардсан БХБЯ-ны олгогдсон ЗТ-7.3 Бага хүчин чадлын цахилгааны эх үүсвэр, (бие даасан болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр) түүнтэй холбогдох шугам сүлжээ, барилга, байгууламжийн технологийн зураг төсөл болон түүнээс дээш гэсэн тусгай зөвшөөрлийг ЗТ-3.6 Цахилгаан дамжуулах шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг гэсэн тусгай зөвшөөрлөөр дүйцүүлж болно гэж үнэлгээний хороо шийдвэрлэсэн.

Бусад шаардлагатай материалыг батлагдсан зураг, төсөв, тендерийн баримт бичгийн дагуу материалаа бүрдүүлэн ирүүлнэ үү

Жич: Тус тодруулгатай холбоотойгоор асуух зүйл байвал доорх хаягаар тодруулж болно.

Сонгинохайрхан дүүрэг, 27 дугаар хороо, Баянголын 1 дүгээр гудамж, 3 давхарт, 302 тоот, Нутгийн захиргааны нэгдсэн байр, Худалдан авах ажиллагааны алба

Цахим шуудангийн хаяг: haaashd24@gmail.com, Утасны дугаар: 7000 0717